МЭДЭЭ · 2020 оны 2-р сарын 20

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГА COVID-19 ВИРУСААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ АЖИЛЛАЖ БАЙНА






Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн шийдвэрээр улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор Улсын Ерөнхий Прокурорын газар, аймаг, Нийслэл, Тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрууд шинэ короновирусийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч ажиллаж байна.

Тухайлбал, нийт прокурор, ажилчид болон байгууллагад гаднаас нэвтэрч байгаа иргэдийн биеийн халууныг нь хэмжиж, амны хаалт зүүх шаардлага тавьж байгаагаас гадна үүдний хэсэг, ариун цэврийн өрөөнд гар ариутгагч халдваргүйжүүлэлтийн уусмал, халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж зэргийг байршуулан, ажлын өрөө, тасалгааг тогтмол ариутгаж байна. Мөн хурууны хээгээр ажлын цаг бүртгэх төхөөрөмжийг түр хугацаанд ашиглахгүй байхаар боллоо.



Нийслэлийн прокурорын газар



Дархан-Уул аймгийн прокурорын газар


ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ, ТӨР,
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ПРОКУРОРЫН ГАЗАР
ЗӨВШӨӨРӨЛГҮЙ
НЭВТРЭХИЙГ
ХОРИГЛОНО!


УУЧДААРАЙ,
ТҮР ХҮЛЭЭНЭ ҮҮ


Kills 99.9% of
Crisp
Lemon
BLEACH-FREE
ЦЭВЭР ГАР
ГАР АРИУТГАГЧ ГЕЛЬ
HAND SANITIZER





Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3052